

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ХАРИЛЦАА

Нийгэм судлал 10-р анги
Багш Д.Уранцэцэг
IV улирал. Хичээл №9

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

- ❑ Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны агуулга, чиглэл, хэлбэрийг жишээгээр тайлбарлаж, үнэлэлт өгөх
- ❑ Монголын эдийн засгийн гадаад харилцааны зорилго, чиглэл, хэлбэрийг бүдүүвч, диаграмаар илэрхийлэх
- ❑ Монгол улсын эдийн засгийн гадаад харилцааны зорилго, чиглэлийг статистик мэдээллийг ашиглан тодорхойлох

ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Эдийн засаг бол ховор хязгаарлагдмал нөөц баялгийг нийгэм ба нийгмийн бүлэг, нэгжүүдийн одоогийн ба ирээдүйн хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор хэрхэн яаж үр дүнтэй ашиглах зарцуулах талаар сонголт хийх шийдлийг судалдаг нийгмийн шинжлэх ухаан юм.
- Эдийн засгийн гадаад харилцаа нь улс төрийн гадаад харилцаанд тулгуурласан аж ахуйн хамтын ажиллагаа, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, гадаадын зээл, тусламж зэрэг эдийн засгийн салбаруудын олон талт, цогц үйл ажиллагаа юм.
- Транзит тээвэр буюу дамжин өнгөрөх тээвэр гэдэг үгийн дор монгол улсын хилийг нэвтрэн монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин гуравдагч оронд хийгдэх тээвэрлэлтийг хэлнэ.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн аюулгүй байдлыг баталгаажуулах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд гадаад харилцааны үр нөлөөг нэмэгдүүлэх нь эдийн засгийн гадаад харилцааны бодлогын зорилго мөн. Эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэхдээ эрх тэгш, харилцан ашигтай байх зэрэг нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг чанд мөрдөнө.

ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

экспортын хэмжээг өсгөхийг дэмжих

Эдийн засгийн салбаруудад тэргүүний технологи, менежмент нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, стандартыг олон улсын жишиг, түвшинд ойртуулах

Импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Дэд бүтцийн сүлжээнд нэгдэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх

Монгол орны байгаль, түүх, соёлын өв санд түшиглэн аялал жуулчлалын үйлчилгээг олон улсын түвшинд хүргэх

ОЛОН УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭРЛЭЛТ

Өнөөгийн байдлаар Монгол улсын гадаад худалдааны нийт ачаа эргэлтийн 95 орчим хувь төмөр замаар тээвэрлэгдэж байна. Төмөр замаар манай улс хөрш орнуудтайгаа холбогдсон учраас экспорт импортын тээвэрлэлтийн аль алиныг хийх боломжтой. Европын орнуудаас ачаа тээвэрлэхэд далайгаар тээвэрлэснээс 2-3 дахин бага хугацаагаар тээвэрлэх боломжтой байдаг. Төмөр замын экспортын тээвэрлэлт сүүлийн жилүүдэд 8 орчим сая тонн-д хүрч байна. БНХАУ болон ОХУ-г холбосон төмөр замаар дэлхийн аль ч улс руу экспорт, импорт, транзит ачааны бүх тээврүүдийг хийх боломжтой.

ОРОСЫН ЧИГЛЭЛ:



Транссибирийн төмөр замаар дамжин ОХУ-ын Санкт-Петербург, Өмнөд Архангельск, Владивосток, Новороссийск боомтууд болон Европын холбооны бүх улсуудтай холбогддог.


ХЯТАДЫН ЧИГЛЭЛ



Хятадын Синган боомт нь Монголд хамгийн ойрхон далайн гарц бөгөөд Замын-Үүд өртөөтэй төмөр замаар шууд холбогддог. Уг далайн боомтыг ашиглан импорт, экспортын тээвэрлэлтийг Хятадын төмөр замаар дамжин БНХАУ-ын газруудад ачаа тээвэрлэлтүүдийг зохион байгуулах бүрэн боломжтой.

ТРАНЗИТ ТЭЭВЭР

Монгол улсын төмөр замын сүлжээ нь Ази, Европын улсуудыг холбосон ачаа тээврийн гүүр болдог онцлогтой.



БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-1

Сурах бичгийн 137-р хуудасны эх сурвалжийг уншаад, дараах ажлын хуудасны асуултын дагуу хариулж бичээрэй

Өөрийн нэр	Хувцасны нэр	Хувцасыг ямар материалаар хийсэн	Хаана үйлдвэрлэ сэн	Монголд импортоор орж ирсэн эсэх

БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-2



Зургийг ажиглаж, Монгол улсын хилийн боомтуудыг ажлын хуудасны асуултын дагуу ялгаж бичээрэй.

№	ОХУ-тай хиллэх боомт	БНХАУ-тай хиллэх боомт
1.		
2.		
3.		
4.		

ГЭРИЙН ДААЛГАВАР

1. Бие дааж хийх даалгавар 1,2 -г дэвтэртээ хийгээрэй.
2. Сурах бичгийн 137-140 хуудсыг сайн уншиж судлаарай.